



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 654

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.4, 6.4.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, 37,000,000.000 (гучин долоон сая) төгрөгийн балансын үнэ, 21,583,333.27 (хорин нэгэн сая таван зуун наян гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашины 3 дахь удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГН

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

000271



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн
637 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИН

Д/д	Автомашинны нэр, марк, улсын бүртгэлийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балагсын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг)
1	Ниссан тийда, 74-92 УНЯ (арал-jп1бсас1120050753)	2012	57811	37,000,000.00	21,583,333.27	15,416,666.73	1,750,000.00
	Нийт дүн			37,000,000.00	21,583,333.27	15,416,666.73	1,750,000.00 (нэг сая долоон зуун тавин мянган)